

ЗӨВЛӨМЖ

Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар илэрсэн нийтлэг зөрчилд үндэслэсэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Сумын ИТХ-ын тогтоолоор сумын төсвийн орлого, зарлага, эх үүсвэрийг батлуулах;

2. Төсвийн хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан мөрдөж ажиллах;

3. Орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын санхүүжилтийг ЗЭБ маягтаар хийж Засаг даргаар батлуулан олгож байх;

4. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг орлогын хуулга, татварын байцаагчийн мэдээтэй тулган зөрүүг арилган хааж байх;

5. Төсөвт байгууллагууд хяналтын хуудсыг бүрэн хөтлөх, QR кодтой төлбөрийн баримтаар гүйлгээ хийж хэвших;

6. Төсвийн тухай хууль, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган төсөвт байгууллага болон сум хөгжүүлэх сангийн өр, авлагыг барагдуулах, шүүхийн шийдвэрээр олгогдсон цалингийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар төлж барагдуулах ажлыг зохион байгуулан арга хэмжээ авч ажиллах;

7. Төсвөөс гадуур төсвийн байгууллага арилжааны банкинд данс нээхгүй байх;

8. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомж, заавар, журмын дагуу батлагдсан төсөвтөө багтаан зөрчилгүй ажиллах, мэдлэг чадвараа дээшлүүлэх;

9. Төсөв захирагч Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6.2, 19.6.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах;

10. Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтан албан хаагчид “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

11. Төсөвт байгууллага хариуцан ажиллаж буй нягтлан бодогч нар өөрийн дансдын орлого, зарлагын гүйлгээг өдөр тутамдаа хянаж. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.12 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

12. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.13-т заасан заалтын хэрэгжилтийг ханган ажиллах. /зарлагын гүйлгээ хийхийг хориглосон заалт бүхий төлбөр тооцоог гүйцэтгэхгүй байх/;

13. Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн, тайланг бодит байдалд нийцүүлэн бичиж, эрсдлийг үнэн бодитоор үнэлэн хугацаанд нь ирүүлэх;

14. Төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авч, өр авлагыг Фрийбаланс программд оруулах, архивын нэгж үүсгэж байх;

15. ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний шууд худалдан авалтыг зохион байгуулахдаа гүйцэтгэгчдээс үнийн санал авах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд санхүүжилтийн хуваарийг тусгах, тендерийн баримт бичиг, гэрээнд тусгаагүй урьдчилгаа санхүүжилтийг олгохгүй байх, холбогдох хууль тогтоомж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн ханган ажиллах;

16. Цалингийн нэгдсэн систем, эрхийн бүртгэлийн сан системүүдэд дадлагажих, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн программаар хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд гаргаж хэвших;

17. Эд хариуцагчийн тайланг сар бүр гаргуулан авч нягтлан бодох бүртгэлтэй тулгаж, хуулийн дагуу тооллого хийж тооцоо бодож байх;

18. Төлбөр тооцоог дамжуулахдаа байгууллагын төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн батлаж хэвших. Батлахдаа эдийн засгийн ангилал, анхан шатны баримт бүрдлийг нэг бүрчлэн нягтлан төлбөр тооцоог дамжуулах;

19. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11 дэх заалтын хүрээнд төрийн сангийн архивын нэгжийг дараа өдөрт багтаан хянан тулгаж, мемориалын баримтыг үүсгэн хэвших;

20. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;

21. Улсын болон орон нутгийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлж ажиллах;

22. Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд мөрдөх журамд заасан ажил үүргийн хуваариар системд нэвтэрч журмыг мөрдлөгө болгон ажиллах;

ХЯНАСАН: САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Х.БААТАРЗОРИГ

ЗӨВЛӨМЖИЙГ НЭГТГЭСЭН: ДОТООД ХЯНАЛТЫН

МЭРГЭЖИЛТЭН

Б.АРИУНЖАРГАЛ